

## Монгол бичгийн үсгийн үндсэн махбод

Дармал	Бичмэл	Титэм. Титмийг бичихдээ ялимгүй толгой гарган дараад, нар зөв эргүүлэн шүд гаргаж татна. Титмийг хэт гогцооруулбал Х, Г, хэт өнцөглөвөл С үсэг шиг болохыг анхаараарай.
ᠠ	ᠠ	<b>Шүд /өргөс, ацаг/.</b> Шүдийг ялимгүй налуу бичнэ. Шүд хоорондын зайг жигд бичнэ. Шүдийг хэт налуу буюу эсвэл эгц бичиж болохгүй.
ᠡ	ᠡ	<b>Шилбэ.</b> Шилбийг шүднээс ялимгүй урт бичнэ. Мөн хэт налуу буюу эгц бичиж болохгүй.
ᠢ	ᠢ	<b>Гэдэс.</b> Гэдсийг нуруу дагуулж, нар зөв эргүүлэн дугуйруулж ялимгүй зууван бичнэ. Хэт том, цондгор, бөөрөнхий, хавчиг бичиж болохгүй.
ᠣ	ᠣ	<b>Сүүл.</b> Сүүлийг шугамаа дагуулж нуруулаад, улмаар үзгийн даралтыг хөнгөрүүлж, сүүлийг уужим татаж бичнэ.
ᠤ	ᠤ	<b>Орхиц буюу цацлага.</b> Орхицыг толгой гаргаад урагш налуулан татаж, үзүүрийг ялимгүй дээш эргүүлнэ.
ᠮ	ᠮ	<b>Нум.</b> Нумыг гол шугамаас урагш шүд татаад, буцаан дугуйлан нумруулж бичнэ.
ᠨ	ᠨ	<b>Гээг.</b> Гээгийг титмийн хойд өнцгөөс залган авч, доош татаж бичнэ.
ᠬ	ᠬ	<b>Эвэр.</b> Эврийг титмийн хойд өнцгөөс эхлэн авч, дээш татаж бичнэ.
ᠵ	ᠵ	<b>Зартиг.</b> Эр үгийн Х, Г үсгийн эхэнд орох ятгар зартигийг бичихдээ гол нурууны ялимгүй ард талаас шинийн саран мэт зурлагыг эхэлж татаад, гараа салгаж нумруулан, шүд гарган нуруунд нийлүүлнэ.
ᠶ	ᠶ	<b>Завж.</b> С, Ш үсгийн эхэнд орох завжийг бичихдээ, гол нуруунаас хотойлгон дарж татаад, хурц өнцөг гарган буцаан шүд хийж, нуруунд нийлүүлнэ.
ᠰ	ᠰ	<b>Дусал.</b> Дуслыг бичихдээ цэглээд орхихгүй, цэгийн төгсгөлийг үл ялиг эргүүлнэ.
ᠱ	ᠱ	<b>Давхар дусал.</b> Давхар дуслыг бичихдээ цэглээд орхихгүй, цэгийн төгсгөлийг үл ялиг эргүүлнэ. (Дуслын зурлагыг давтан бичнэ)
ᠰ	ᠰ	<b>Нуруу.</b> Нурууг махбод хоорондын харьцааг тааруулан шударга (тэгш, шулуун) бичнэ.